

UCS 2102A:2020


ГУДАМЖ ЗАМ, БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ



Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн бичвэр,
тэмдэгт тавигдах шаардлага, байрлуулах, суурилуулах удирдамж

ГУДАМЖ ЗАМ, БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ

Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн бичвэр, тэмдэгт тавигдах шаардлага, байрлуулах, суурилуулах удирдамж



ГАРЧИГ

1. Зорилго	1
2. Хамрах хүрээ	1
3. Норматив эшлэл.....	1
4. Нэр томъёоны тодорхойлолт.....	1
5. Дулаан хангамжийн системийн үйлчлэх хүрээ, ангилал	2
6. Хаягийн тэмдгийн ангилал	3
7. Хаягийн тэмдгийн самбарт тавигдах шаардлага	6
8. Хаягийн тэмдгийн бичвэрт тавигдах шаардлага.....	7
9. Хаягийн тэмдэг байрлуулах.....	7
10. Хаягийн тэмдэг суурилуулах	8
11. Барилгын хаягийн тэмдгийн ажлыг хүлээн авах шалгуур үзүүлэлт	9
Ашигласан материалын жагсаалт	10

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хаягийн иж бүрдэл тэмдэг	3
Зураг 2. Хаягийн иж бүрдэл тэмдэг харагдах байдал	4
Зураг 3. Хаягийн хураангуй тэмдэг.....	4
Зураг 4. Хаягийн тэмдэг	4
Зураг 5. Хаягийн тэмдэг харагдах байдал	5
Зураг 6. Гудамжны нэрийн тэмдэг	5
Зураг 7. Үл хөдлөх хөрөнгийн дугаар тэмдэг.....	6

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хаягийн иж бүрдэл.....	3
Хүснэгт 2. Хүлээн авах шалгуур үзүүлэлт	9

ГУДАМЖ ЗАМ, БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ

Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн бичвэр, тэмдэгт тавигдах шаардлага, байрлуулах, суурилуулах удирдамж

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байрлуулах, суурилуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдамж арга зүйгээр хангахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичгийг барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байрлуулах, суурилуулах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан стандартыг хэрэглэнэ. Эш татсан стандартад өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- MNS 5283:2014 стандарт Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага
- MNS 4597:2014 Замын тэмдэг тэмдэглэл
- MNS 6275:2011 Нэгдсэн хаягжуулалт, хаягийн бичвэрт тавих шаардлага;
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам - Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт

4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Үл хөдлөх эд хөрөнгө – гэж газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсыг ойлгоно.

Хаяг – гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, батлагдсан газар зүйн нэр бүхий газар нутаг, хот, суурин газар дахь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлыг тодорхойлсон үсэг, тооны илэрхийллийг;

Хаягийн иж бүрдэл – гэж үл хөдлөх эд хөрөнгийн байршлын мэдээллийг шуудангийн нэгдсэн кодын хамт хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд дэлгэрэнгүй болон товчлол хэлбэрээр бүртгэсэн хаягийн нэгдсэн мэдээллийг;

Хаягжуулах – гэж үл хөдлөх эд хөрөнгөд дугаар олгох, хаягийн мэдээллийн санд бүртгэх, хөтлөх, өөрчлөх, хүчингүй болгох, хаягийн зураг зохиох, хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах цогц үйл ажиллагааг;

Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем – гэж үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн бүртгэлийг удирдах, зохион байгуулах, хөгжүүлэх, өгөгдөл, мэдээлэл цуглуулах, солилцох, дамжуулах, боловсруулах, хадгалах боломжтой төрийн мэдээллийн бусад сантай харилцан уялдаа бүхий цогц үйл ажиллагаатай цахим программ хангамжийг;

Газрын хаяг – гэж үл хөдлөх хөрөнгө баригдаагүй газрын кадастрын зураг эзэмшил өмчлөл бүхий газрыг;

Хаягийн тэмдэг – гэж стандартын дагуу үйлдвэрлэн, газарт суулгах зориулалтын тулгуур дээр бэхэлсэн гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн баталгаажсан нэр, дугаар, тухайн объект хүртэлх зайн хэмжээ бүхий тэмдгийг;

Шуудангийн нэгдсэн код – гэж барилга байгууламжид оноогддог бөгөөд бүсчлэлийн 5 оронтой тоо дээр 4 оронтой тоог залгуулан оноодог тоог.

5. ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, АНГИЛАЛ

- 5.1. Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангаж, оршин байгаа байрлалыг төвөггүй хялбар олох боломжыг бий болгохын тулд барилга үл хөдлөх эд хөрөнгө тус бүр стандартад нийцсэн хаягтай байна.
- 5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлаж байгаа гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг “Хаягжуулалтын тухай хууль”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” (ЗГ -ийн 325 дугаар тогтоол, 2019 он) -ийн хүрээнд хаягжуулна.
- 5.3. Барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгөд дугаар олгоход Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журмыг баримтална. (НИТХ -ын Тэргүүлэгчдийн 269 дүгээр тогтоол, 2006 он)
- 5.4. Үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 5.4.1. Байр зүйн зурагт суурилсан байх;
 - 5.4.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт нийцсэн байх;
 - 5.4.3. Хаяг давхардахгүй байх;
 - 5.4.4. Хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх;
 - 5.4.5. Кадастрын бүртгэлээр баталгаажсан байх;
 - 5.4.6. Хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх;
 - 5.4.7. Хаягийн талаарх мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх;
- 5.5. Барилга байгууламж үл хөдлөх эд хөрөнгө бүр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, батлагдсан газар зүйн нэр бүхий газар нутаг, хот, суурин газар дахь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлыг тодорхойлсон үсэг, тооны илэрхийллийг ойлгох бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө хаяг авч, бүртгэгдсэн байна.
- 5.6. Хаяг нь үл хөдлөх эд хөрөнгийн байршлын мэдээллийг шуудангийн нэгдсэн кодын хамт хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд дэлгэрэнгүй болон товчлол хэлбэрээр бүртгэсэн хаягийн нэгдсэн мэдээллийг агуулсан иж бүрдэл байна. Хаягийн иж бүрдлийг хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Хаягийн иж бүрдэл

№	Хаягийн иж бүрдэл	Нийслэлд /Жишээ/
1	Улс:	Монгол Улс
2	Аймаг, нийслэл:	Улаанбаатар
3	Дүүрэг:	Чингэлтэй
4	Хороо:	1 (хороо)
5	Шуудангийн бүсчлэлийн код:	15201
6	Гудамжны нэр:	Ц.Жигжиджав
7	Үл хөдлөх эд хөрөнгө /хашаа, барилга байгууламж/	7/1

5.7 Хаягийн иж бүрдэлд хороолол, хотхоны нэр, өрөө, сууцны давхрын дугаар, геокод (тухайн газар, үл хөдлөх эд хөрөнгө, байршил, эсхүл объектын байршилд харгалзах уртраг, өргөрөг бүхий солбицол), бизнес хаяг зэрэг бусад мэдээллийг нэмэлтээр бүртгэж болно.

5.8 Барилга, байгууламж, үл хөдлөх эд хөрөнгийн хаяг нь дараах мэдээллээс бүрдэнэ:

- нийслэл, аймаг болон сумын төв, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгонд гудамж /зам, талбай, хороолол, хотхон/-ийн нэр, дугаар, хашаа, барилга байгууламжийн нэр, эсхүл дугаар, хаалганы дугаар зэрэг мэдээлэл;
- газар зүйн /газар, усны/ нэр, хашаа, барилга байгууламжийн нэр, эсхүл дугаар, хаалганы дугаар зэрэг мэдээлэл.


6. ХАЯГИЙН ТЭМДГИЙН АНГИЛАЛ

Барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хаягийн иж бүрдэл тэмдэг;
- Хаягийн хураангуй тэмдэг;
- Хаягийн тэмдэг;
- Гудамжны нэрийн тэмдэг;
- Үл хөдлөх хөрөнгийн дугаар тэмдэг;

6.1. Хаягийн иж бүрдэл тэмдэг

Хаягийн иж бүрдэл тэмдгийг барилга үл хөдлөх хөрөнгийн гол хаалганы хажууд хийж байрлуулж болох бөгөөд тус тэмдгийн жишиг загварыг Зураг 1 -т үзүүлэв.




Байрлал: Барилгын гол хаалганы хажууд

Самбарын хэмжээ:
Өндөр 40 см
Өргөн 65 см

Материал: Металл

Зураг 1. Хаягийн иж бүрдэл тэмдэг



Зураг 2. Хаягийн иж бүрдэл тэмдэг харагдах байдал

6.2. Хаягийн хураангуй тэмдэг

Хаягийн хураангуй тэмдгийг барилга үл хөдлөх хөрөнгийн гол хаалганы хажууд хийж байрлуулж болох бөгөөд тус тэмдгийн жишиг загварыг Зураг 3 -т үзүүлэв.



Байрлал: Барилгын гол хаалганы хажууд

Самбарын хэмжээ:

Өндөр 40 см


Өргөн 65 см

Материал: Металл


Зураг 3. Хаягийн хураангуй тэмдэг

6.3. Хаягийн тэмдэг

Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдгийн зай хэмжээ, ерөнхий харагдах байдлыг Зураг 4-т үзүүлэв.



Зураг 4. Хаягийн тэмдэг



Зураг 5. Хаягийн тэмдэг харагдах байдал

6.4. Гудамжны нэрийн тэмдэг


Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн тэмдгийг гудамжны нэрийн тэмдэгтэй хамт хэрэглэх бөгөөд тус тэмдгийг үндэсний стандарт болон Хотын стандарт UCS 2103A:2020 “Гудамжны нэрийн тэмдэг байрлуулах, суурилуулах удирдамж” -ийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэж байрлуулна. Гудамжны нэрийн тэмдгийг Зураг 6-т үзүүлэв.



Зураг 6. Гудамжны нэрийн тэмдэг

6.5. Үл хөдлөх хөрөнгийн дугаар тэмдэг

Үл хөдлөх хөрөнгийн дугаар тэмдэгт нийтийн орон сууцны орц болон үл хөдлөх хөрөнгийн дугаар тэмдэг орох бөгөөд тэмдгийн хэмжээ болон харагдах байдлыг Зураг 7 -т үзүүлэв.



Зураг 7. Үл хөдлөх хөрөнгийн дугаар тэмдэг

7. ХАЯГИЙН ТЭМДГИЙН САМБАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 7.1. Гадна хаягийн тэмдгийг байгаль цаг уурын өдөр шөнө сайн зэвэрдэггүй, хугардаггүй, халцардаггүй материалаар хийнэ.
- 7.2. Хаягийн тэмдгийн дэвсгэр өнгийг Монгол Улсын стандарт “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS4597:2014 стандартад нийцүүлнэ.
- 7.3. Хаягийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүйгээс гадна шөнийн цагт саадгүй харагдах, тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материалаар хийнэ.
- 7.4. Гудамжны нэрийг хөх өнгийн дэвсгэртэй 120x35 см хэмжээтэй самбар дээр цагаан өнгөөр бичиж гудамжны эхний барилгын хананд буюу зориулалтын шон дээр хадаж байрлуулна. Самбар нь захаасаа 0.5 см зайтай 1.5 см өргөн цагаан өнгийн хүрээтэй байна. Зориулалтын шон дээр байрлуулах самбар нь чиглэл заасан өнцөгтэй байх ба шонгийн өндөр 3-3.5 м байна.
- 7.5. Гудамжны дагуу барилгын дугаарыг өмнөх заалтаар хийгдсэн гудамжны нэрийн ард 35x35 см хэмжээтэй гудамжны нэртэй ижил хөх өнгийн дэвсгэртэй самбарт цагаан өнгөөр бичиж байрлуулна.
- 7.6. Тухайн байшингийн гудамжны эсрэг талд байрлуулах дугаар нь 50x50 см хэмжээтэй, хөх дэвсгэр дээр захаасаа 0.5 см зайтай 1.5 см өргөн цагаан хүрээтэй самбар дээр цагаанаар бичигдсэн байна.
- 7.7. Хаягийн тэмдгийн өнгө нь байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүйгээс гадна шөнийн цагт саадгүй харагдах, тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материалаар хийнэ.

8. ХАЯГИЙН ТЭМДГИЙН БИЧВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 8.1. Хаягийн бичвэр нь Монгол хэлний тухай хууль, Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, Кирилл монгол бичгийн дүрэм, “Монгол бичгийн цагаан толгой” MNS 4333:1996 шаардлагад нийцсэн байна.
- 8.2. Хаягийн тэмдгийн самбар дээрх бичлэг нь нүдэнд харагдахуйц байх бөгөөд шрифтийн хэмжээ нь тэмдэгтийн тооноос хамаарна.
- 8.3. Гудамжны нэр, барилгын дугаар бичих үсэг болон цифрийн өнгө цагаан байна.
- 8.4. Дугаарлалт болон бичвэр нь хэвтээ байна.
- 8.5. Гудамж болон барилгын дугаарыг бичих үсгийн хэлбэр нь Arial байна. (Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журам).
- 8.6. Бичлэгийг MNS ISO 3098–6:2003, MNS ISO 3098-2:2003 стандартын дагуу хийнэ.
- 8.7. Гудамж, талбайн нэрлэсэн нэр болон барилгын дугаарыг бичих цифрийн хэлбэр нь Монголын албан ёсны бичгийн нэгдсэн фонд болох Arial байна.
- 8.8. Хаягийн тэмдгийн бичлэгт гудамж, өргөн чөлөө, талбай, хотхон, барилга гэсэн үгнүүдийг товчлохдоо MNS 6275:2011 стандартын А хавсралтыг, аймаг, хотуудын нэрийг товчлохдоо В хавсралтыг тус тус баримтлана.

9. ХАЯГИЙН ТЭМДЭГ БАЙРЛУУЛАХ

- 9.1. Хаягийн тэмдгийг гэр хорооллын гудамжны зүүн гар талын эхний болон төгсгөлийн хашааны дээд булан дээр хашааны дээд болон булангийн ирмэгээс тус бүр 200 мм-ийн зайд байрлуулна.
- 9.2. Барилга, байшингийн гадна тавих дугаарын тэмдгийг тухайн байшин, барилгын зорчигч их байдаг талын 2 хананд, 2 ба 3 дугаар давхрын хооронд, ил харагдахаар байрлуулна.
- 9.3. Байшин, барилга 1 давхар бол тухайн байшин, барилгын зорчигч их байдаг талын 2 хананд, 1 давхрын дээд хэсэгт байрлуулна.
- 9.4. 2 давхраас дээш байшин барилгад зорчигч их байдаг талын 2 хананд, 2 ба 3 дугаар давхрын хооронд, ил харагдахаар байрлуулна.
- 9.5. Орцны дугаарын тэмдгийг тухайн орцны хаалганы дээд хэсэгт хадах бөгөөд тэмдгийн баруун үзүүрт тухайн орцонд байгаа байрнуудын хаалганы дугаарыг заавал бичсэн байна.
- 9.6. Хашааны дугаарын тэмдгийг хаалганы баруун гар талын хашааны дээд хэсэгт ирмэгүүдээс тус бүр 200 мм-ийн зайд хадна.
- 9.7. Зам дагуу байрлуулах хаягийн тэмдгийн суурь өндөр нь “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын 4.1.9-д заасан шаардлагад нийцсэн байна.

10. ХАЯГИЙН ТЭМДЭГ СУУРИЛУУЛАХ

- 10.1 Нэрийн тэмдгийн самбарыг байрлуулах, суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгыг урьтал болгох бөгөөд тэмдгийг салхинд унахгүйгээр бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх бөгөөд олон нийтийн гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 10.2 Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг байрлуулахдаа “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” болон стандартыг баримтална.
- 10.3 Хаягийн тэмдгийн тулгуур шонгын суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.
- 10.4 Суурийг цутгалтын аргаар гүйцэтгэхэд БНБД 52-02-05-ыг мөрдлөг болгоно.
- 10.5 Элсийг стандартын шаардлагад тохирсон, бетон зуурмаг MNS1185:1985 техникийн шаардлагыг хангасан байна.
- 10.6 Хаягийн тэмдгийн тулгуур суурийг барилгын зургийн инженерийн зураг төслөөр хийж, хянаж шалгасан, батлагдсан орц, нормын дагуу хийж, байгалийн аливаа үзэгдэлд тэсвэртэй, мал, амьтан шөргөөхөд унахааргүй газарт бат бөх суурилуулсан байна.
- 10.7 Гудамж, зам, талбай өргөн чөлөөнд байрлуулсан хаягийн тэмдгийн 5 м-ийн радиуст багтах орчинд төрөл бүрийн рекламн самбар, эд зүйлс, мөн тэдгээрийг замын ногоон байгууламж, гэрэлтүүлгийн шон гэх мэт зүйлсээр халхлахгүй, ашиглах болон үйлчилгээ хийхэд тохиромжтой байхаар суурилуулсан, санамсаргүйгээр гэмтэхээс сэргийлсэн байна.

11. БАРИЛГЫН ХАЯГИЙН ТЭМДГИЙН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажил, хаягийн бичвэр, тэмдэгт тавигдаж байгаа материалын шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 2.)-ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 2. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Албан ёсны хаяг болон хаягийн тэмдгийн мэдээлэл тохирч байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хаягийн тэмдгийн бичвэр үг, үсгийн алдаагүй зай хэмжээний шаардлага хангаж байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Тэмдгийн хэмжээ стандартын шаардлага хангаж байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Өнгө, гэрэл ойлголт стандарт шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Тэмдгийг зөв байрлуулсан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Тэмдгийн суурилуулалт бэхэлгээ шаардлага хангаж байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Монгол улсын Хаягжуулалтын тухай хууль 2013 он
- Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам;
- MNS 5283:2014 стандарт Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага;
- MNS 6275:2011 Нэгдсэн хаягжуулалт, хаягийн бичвэрт тавих шаардлага;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 12 дугаар сарын 06 өдрийн 269 дугаар тогтоол “Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга байгууламжид дугаар олгох журам;
- S42 Дэлхийн шуудан холбооны хаягийн бичвэрийн стандарт International Addressing Standards



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар